

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,  
САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

---

2023 оны ..... дүгээр  
сарын ..... -ны өдөр

Дугаар .....

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5, 12 дугаар зүйлийн 12.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Хүүхэд хамгаалах үйлчилгээний зардлын дундаж норматив, санхүүжүүлэх аргачлал, нэмэгдэл урамшуулал олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Хүүхэд хамгааллын үйлчилгээг “Хүүхэд хамгаалах үйлчилгээний зардлын дундаж норматив, санхүүжүүлэх аргачлал, нэмэгдэл урамшуулал олгох журам”-ын дагуу санхүүжүүлж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар /Н.Өлзийхутаг/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн захиргаа удирдлагын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Д.Батсүх/, аймаг, нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүл, бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Н.Баярмаа/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Учрал/-т даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23/27 дугаар “Аргачлал, зардлын норматив батлах тухай” хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэхүү тушаалыг 2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД

САНГИЙН  
САЙД

Х.БУЛГАНТУЯА

Б.ЖАВХЛАН

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын  
сайд, Сангийн сайдын 2023  
оны.....дугаар хамтарсан тушаалын  
хавсралт

## ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВ, САНХҮҮЖҮҮЛЭХ АРГАЧЛАЛ, НЭМЭГДЭЛ УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Хүүхэд хамгааллын дараах үйлчилгээг санхүүжүүлэхэд энэхүү аргачлалыг ашиглана. Үүнд:

- 1.1.1.шуурхай тусламжийн;
- 1.1.2.хамгаалах, нөхөн сэргээх;
- 1.1.3.урьдчилан сэргийлэх.

1.2.Хүүхэд хамгааллын үйлчилгээ (цаашид “Үйлчилгээ” гэх)-ний санхүүжилтийг цахим мэдээллийн сан дахь тохиолдол (цаашид “Кейс” гэх)-ын тоо, үзүүлсэн үйлчилгээний үр дүнд үндэслэн олгоно.

1.3.Үйлчилгээний санхүүжилтийг хавсралтаар батлагдсан нормативд үндэслэн энэхүү журмын 1.1-д заасан үйлчилгээ тус бүрээр тооцож, орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагаас Хамтарсан баг, хүн, хуулийн этгээд, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх магадлан итгэмжлэгдсэн байгууллагад олгоно.

*Тайлбар:-Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага журмын дагуу магадлан итгэмжилнэ.*

1.4.Хамтарсан баг нь шуурхай тусламжийн болон хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ тус бүрээр “Хамтарсан багийн санхүүгийн хүсэлт”-ийг кейс тухай бүр гаргана. Шаардлагатай тохиолдолд нэмэлт санхүүжилтийн хүсэлтийг гаргана.

*Тайлбар:-Кейс менежментийн үе шат, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу шаардагдах зардлыг тухайн хүсэлтэд тусгах бөгөөд хүсэлтийг хамтарсан багийн нарийн бичиг боловсруулж багийн ахлагч гаргана. Хүсэлтийг хамгааллын үйл ажиллагааны арга зүйн дагуу боловсруулсан эсэх талаар асуудал хариуцсан мэргэжилтэн, холбогдох зардлыг аргачлал, батлагдсан нормативын дагуу тусгасан эсэх, байгууллагын батлагдсан төсөв болон санхүүжилтийн сар, улирлын хуваарьтай уялдаж буй талаар нягтлан бодогч хянаж, нэгжийн шууд захирагч батална.*

1.6. Аймаг, нийслэлийн засаг дарга болон Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, орон нутаг дахь хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага нь батлагдсан төсвийг үйлчилгээ тус бүрээр үр дүнд суурилсан байдлаар төлөвлөж, үр дүнтэй байх, өр, авлага үүсгэхгүй байх зарчмыг баримтлан санхүүжүүлнэ.

### Хоёр. Шуурхай тусламжийн үйлчилгээний зардлыг тооцох

2.1.Шуурхай тусламжийн үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд нөхцөл байдлын үнэлгээ хийх, кейс нээхэд шаардлагатай бичиг хэргийн зардал, шуудан

холбооны зардал, тээвэр шатахууны зардал, үйлчилгээний анхан шатны багцын зардал тус тус багтана.

*Тайлбар:-Тухайн тохиолдолд үзүүлэх үйлчилгээний онцлог, хүчирхийллийн хэлбэрээс шалтгаалан энэхүү журмын 2.1-т заасан зардлаас холбогдох зардлыг сонгож санхүүжүүлнэ.*

2.2.Үйлчилгээний анхан шатны багцад хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээнд нэн тэргүүнд шаардлагатай ариун цэврийн хэрэгсэл, нэг удаагийн хувцас, хүнс, зөөлөн эдлэл авах зардлыг тооцно.

2.3.Тус үйлчилгээний зардлыг магадлан итгэмжлэгдсэн Төрийн бус байгууллагаар гүйцэтгэхээр бол тухайн кейст шаардагдах зардлыг батлагдсан дундаж нормативын дагуу тооцож санхүүжүүлж болно.

2.4.Хамтарсан багийн баталгаажсан санхүүгийн хүсэлтийг үндэслэн тухайн кейсийн шуурхай үйлчилгээний санхүүжилтийг сар бүр тооцож, эрх бүхий байгууллага, хамтарсан багт олгоно.

*Тайлбар:-Санхүүгийн баримтыг 5 хоногт багтаан ирүүлнэ. Тухайн сардаа үйлчилгээ үзүүлсэн кейсийн санхүүгийн хүсэлтийг бүрдүүлж ирүүлээгүй тохиолдолд зардлыг нөхөн олгохгүй.*

### **Гурав. Хүүхэд хамгаалал, нөхөн сэргээх үйлчилгээний зардлыг тооцох**

3.1.Хүүхэд хамгаалал, нөхөн сэргээх үйлчилгээний зардал нь дараах нөхцөлөөс шалтгаалан ангилагдана. Үүнд:

3.1.1.Үйлчилгээ үзүүлэх байршлаас шалтгаалсан. Үүнд:

- а.гэр бүлийн орчинд;
- б.гэр бүлийн бус орчинд.

3.1.2.Хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрээс шалтгаалсан. Үүнд:

- а.бие махбодын;
- б.бэлгийн;
- в.сэтгэл санааны;
- г.үл хайхрах.

3.2.Хүүхэд 3.1.2-т заасан хэлбэрийн хүчирхийлэлд хавсарсан байдлаар өртсөн тохиолдолд аль нэг голлох хэлбэрт хамааруулж, зардлыг тооцож олгоно.

3.3.Хүүхэд хамгаалал, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх зардлын бүрэлдэхүүнд холбон зуучлах зардал, бичиг баримт баталгаажуулах зардал, хамтарсан багийн гишүүдийн нэмэгдэл урамшуулал, үйлчилгээ хамрагдаж буй хүүхдийн хоолны зардал, шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйн үйлчилгээ, хууль зүйн үйлчилгээ, эрүүл мэндийн төлбөртэй үйлчилгээ, тусгай хэрэгцээнд тулгуурласан үйлчилгээ, үйлчилгээ авч буй хүүхдэд шаардлагатай хөгжлийн үйлчилгээний зардал, үйлчилгээний нэмэлт багц, үйлчилгээ үзүүлж буй ажилтнуудын үйл ажиллагааг дэмжих зардал тус тус багтана.

*Тайлбар:-Тухайн кейст үзүүлэх үйлчилгээний онцлог, хүчирхийллийн хэлбэр, байршлаас шалтгаалан энэхүү журмын 3.3-т заасан зардлаас зөвхөн холбогдох зардлыг сонгож санхүүжүүлнэ. Хэрвээ тухайн кейст, нэг гэр бүлийн, нэгээс дээш хүүхэд бүртгэгдэн үйлчилгээнд хамрагдаж байгаа бол хүүхдийн тоонд үндэслэн холбогдох зардлыг санхүүжүүлнэ.*

3.4.Хүүхэд хамгаалал, нөхөн сэргээх үйлчилгээнд баримтлах дундаж үзүүлэлтийг дараах байдлаар тогтооно.

| Зардлын төрөл         | Хэмжих нэгж | Бие махбодын хүчирхийлэл | Бэлгийн хүчирхийлэл | Сэтгэл санааны хүчирхийлэл | Үл хайхрах хүчирхийлэл |
|-----------------------|-------------|--------------------------|---------------------|----------------------------|------------------------|
| Хоолны зардал         | хоног       | 49                       | 182                 | 49                         | 14                     |
| Нэмэгдэл урамшуулал   | хүн/цаг     | 28                       | 92                  | 28                         | 8                      |
| Сэтгэл зүйн үйлчилгээ | удаа        | 8                        | 18                  | 18                         | 4                      |

*Тайлбар:-Тухайн үзүүлэлт нь үйлчилгээнд баримтлах дундаж үзүүлэлт бөгөөд хүчирхийллийн хэлбэр, байршил, тарифаас шалтгаалан зардлын төрлийг сонгохдоо журмын 3.4-т заасан үзүүлэлтээс тухайн кейсийн хэмжүүрийг бодитоор тооцож санхүүгийн хүсэлтэд тусгана. Жишээ нь: Бие махбодын хүчирхийлэлд өртсөн хүүхдийг гэр бүлийн орчноос тусад нь 20 хоног байршуулсан бол 20 хоногоор, хамтарсан багийн 4 гишүүн 5 хүн/цаг ажилласан бол нийт 20 хүн/цагаар санхүүгийн хүсэлт гаргана.*

Тухайн төсвийн жилд байгууллагын Хүүхэд хамгаалал, нөхөн сэргээх үйлчилгээнд хэрэглэсэн нийт үзүүлэлтийн дундаж нь журмын 3.4-т заасан үзүүлэлтээс зардлын төрөл, хүчирхийллийн хэлбэр тус бүрээр ихгүй байна.

3.5.Хамтарсан багийн гишүүдэд олгох нэмэгдэл урамшууллын зардлыг сум, дүүргийн нийгмийн ажилтны үндсэн цалинг суурь болгон кейсийн тохиолдол бүрд энэхүү журмын 3.1.2-т заасан хүчирхийллийн хэлбэр тус бүрээр ялгаатай байдлаар, журмын 3.4-т заасан хүн/цагийг баримталж хамтарсан багийн гишүүн бүрд сар бүр тооцож, улирал бүр олгоно.

3.6.Хамтарсан багийн нарийн бичиг нь гишүүдийн тухайн кейст чиг үүргийн дагуу оролцож, үр дүнтэй үйлчилгээ үзүүлсэн байдлаар нь гишүүдийн оролцоог хүн/цагаар тооцож, хамтарсан багийн хуралдааны тэмдэглэлээр баталгаажуулж санхүүгийн хүсэлтэд тусгана.

3.7.Хамтарсан багийн ахлагч нь орон нутаг дахь хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын төсвийн шууд захирагчтай үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны болон санхүүжилтийн гэрээ байгуулах бөгөөд уг гэрээнд хамтарсан багийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна. Гэрээний жишиг загварыг Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

3.8.Хэрвээ өмнө нь үйлчилгээ үзүүлсэн кейсийн тохиолдол давтагдвал хамтарсан багийн гишүүдэд нэмэгдэл урамшуулал олгохгүй.

*Тайлбар:-Тухайн кейс дэх хүчирхийллийн хэлбэр, үйлчилгээнд хамрагдсан хүүхэд, гэр бүл, асран хамгаалагч нь ижил байвал кейс давтагдсан гэж үзнэ.*

3.9.Үйлчилгээ авч буй хүүхдийн хоолны зардлыг зөвхөн гэр бүлийн бус орчинд үйлчилгээ үзүүлж буй хүүхдэд, журмын 3.4-т заасан хоногийг баримтлан тооцно.

*Тайлбар:-Гэр бүлийн бус орчинд гэдэгт Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байр, асрамж халамжийн төв, асралт гэр бүл хамаарна.*

3.10.Сэтгэл зүйн үйлчилгээ шаардлагатай тохиолдолд журмын 3.4-т заасан нэгжээр тооцож, ажлын хөлсийг олгоно.

3.11.Хууль зүйн үйлчилгээ шаардлагатай тохиолдолд ажлын жишиг хөлсийг хүн/цагаар тооцож, ажлын хөлсийг олгоно.

3.12.Шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн, тусгай хэрэгцээнд тулгуурласан төлбөртэй тусламж үйлчилгээг гүйцэтгэлийг үндэслэн санхүүжүүлж болно.

3.13.Тус үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжлийн үйлчилгээний зардалд хүүхдийг тайвшруулах тоглоом, хамгаалах байранд байрлаж үйлчилгээ авч буй хүүхдэд зориулж ном, дэвтэр, харандаа зэрэг цагийг үр дүнтэй өнгөрүүлэх үйл ажиллагааны зардлыг багтаан тооцно.

3.14.Кейст үзүүлэх үйлчилгээний давтамж, онцлогоос шалтгаалан шаардлагатай тохиолдолд үйлчилгээний нэмэлт багц, тээвэр шатахууны зардлыг тус үйлчилгээнд зарцуулж болно. Үйлчилгээний нэмэлт багцад хүүхдийн нас, хүйс, биеийн онцлог, хүчирхийллийн хэлбэрээс шалтгаалсан хүнс, эм хэрэгсэл, ариун цэврийн хэрэгсэл, хувцас, түлээ, түлш зэрэг нэмэлт хэрэглэлийн зардлыг тооцно.

3.15.Үйлчилгээний төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт орж, кейст үзүүлэх үйлчилгээнд нэмж зардал шаардагдахаар бол нэмэлтээр санхүүгийн хүсэлтийг хамтарсан баг гаргаж болно.

3.16.Үйлчилгээг үзүүлж буй хамтарсан багийн гишүүдийн үйл ажиллагааг дэмжих зардал багтах бөгөөд уг зардлыг сард нэг удаа олгоно.

3.17.Тээвэр шатахууны зардлыг гүйцэтгэл тус бүрд замын тооцооны хуудас болон холбогдох анхан шатны санхүүгийн баримтыг үндэслэн олгоно.

3.18.Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж буй Хамтарсан багийн гишүүн болон албан тушаалтанд Сангийн сайдын баталсан тушаалыг баримтлан албан томилолтын зардлыг олгож болно.

3.19.Магадлан итгэмжлэгдсэн Төрийн бус байгууллагаар үйлчилгээ үзүүлж зардал гаргахаар бол тухайн кейст шаардагдах зардлыг батлагдсан нормативын дагуу тооцож орон нутаг дахь хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага гэрээний үндсэн дээр санхүүжүүлж болно.

3.20.Үйлчилгээ үзүүлсэн магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага, Хамтарсан багийн баталгаажсан санхүүгийн хүсэлтийг үндэслэн тухайн кейсийн хүүхэд хамгаалал, нөхөн сэргээх үйлчилгээний санхүүжилтийн 70 хувийг баталгаажсан санхүүгийн хүсэлт ирүүлсний дараа, 30 хувийг кейс хаасны дараа ажлын 5 хоногт багтаан тус тус олгоно.

#### **Дөрөв. Урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардлыг тооцох**

4.1.Урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд сургалтын хэрэглэгдэхүүний зардал, сургагч багшийн цагийн хөлс, нөлөөллийн ажлын зардал, цайны зардал, хүүхдийн хөгжлийн үйлчилгээний зардал багтана.

4.2.Хүүхдэд чиглэсэн буюу хүүхдийг эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалах, тэдний оролцоог дэмжих зэрэг агуулга бүхий сургалт, нөлөөллийн ажлын зардлыг орон нутгийн хүүхдийн тоонд үндэслэн тооцно.

4.3.Олон нийтэд чиглэсэн буюу хүүхдийн эсрэг хүчирхийллийг үл тэвчих хандлага, соёлыг бэхжүүлэх зэрэг агуулга бүхий сургалт, нөлөөллийн ажлын зардлыг тухайн орон нутгийн хүн амын тоонд үндэслэн тооцно.

4.4.Эцэг, эх, гэр бүлд чиглэсэн буюу хүний эрх, жендэр, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэн болгох арга аргачлал, амьдрах ухаан, гэр бүлийн боловсрол олгох, хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэх, явуулын үйлчилгээ үзүүлэх зэрэг агуулга бүхий сургалт, нөлөөллийн ажлын зардлыг тухайн орон нутгийн өрхийн тоонд үндэслэн тооцно.

4.5.Хүүхэд хамгааллын салбарын болон салбар дундын байгууллагуудын хүний нөөцийг чадавхжуулах, салбар дундын зохицуулалтыг хангах зэрэг агуулга бүхий сургалт, нөлөөллийн ажлын зардлыг хамтарсан багийн гишүүдийн тоонд үндэслэн тооцно.

4.6.Хүүхэд хамгааллын үйлчилгээг авч буй хүүхдийн хөгжилд чиглэсэн буюу хүүхдийн нас, сэтгэхүй, хөгжлийн онцлогт тохирсон аливаа төрлийн сургалт, нөлөөллийн ажлын зардлыг эрсдэлт нөхцөлд буй хүүхдийн тоо, үйлчилгээний төлөвлөгөөнд үндэслэн тооцно.

4.7.Орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын нийт урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардал нь энэхүү журмын 4.2-4.6 дахь заалтыг үндэслэн тооцсон зардлын нийлбэр байна.

### **Тав. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх**

5.1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь тухайн орон нутаг дахь хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дараах чиглэлээр хяналт, шалгалт хийж, үнэлгээ өгнө.

5.1.1.Үйлчилгээ үзүүлэгчид нь хүүхэд хамгааллын түвшин бүрээр кейсийг зөв, оновчтой төлөвлөсөн эсэх;

5.1.2. Үйлчилгээ үзүүлэгчид нь энэхүү журмын 3.1.1, 3.1.2 дахь хэсэгт заасан нөхцөлөөс шалтгаалсан кейс тус бүрийн зардлын бүрэлдэхүүнийг журамд заасны дагуу тооцож санхүүгийн хүсэлт гаргасан, холбогдох албан тушаалтан журмын дагуу баталгаажуулсан эсэх.

5.2.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь журмын хэрэгжилтэд үйл ажиллагааны болон санхүүгийн чиглэлээр хяналт, шалгалт хийх хөндлөнгийн үнэлгээг эрх бүхий этгээд, хувь хүнтэй гэрээ байгуулан улирал тутам хэрэгжүүлнэ. Холбогдох санхүүжилтийг урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардлаас санхүүжүүлнэ.

5.3.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь журмын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний тайланг хагас жил болон жилийн эцэст дараа сарын 15-ны дотор Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

---oOo---

Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын дундаж норматив, санхүүжүүлэх аргачлал, нэмэгдэл урамшуулал олгох журмын хавсралт

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВ /төгрөгөөр/

| №  | Зардлын утга  | Зардлын норматив |
|----|---|------------------|
| 1  | Бичиг хэргийн зардал  | 5,000            |
| 2  | Шуудан холбооны зардал  | 4,000            |
| 3  | Тээвэр, шатахууны зардал  | 20,000           |
| 4  | Хүүхэд хамгааллын үйлчилгээний анхан шатны багц   | 20,000           |
| 5  | Холбон зуучлах зардал   | 4,000            |
| 6  | Бичиг баримтжуулах зардал   | 6,500            |
| 7  | Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж буй ажилтнуудын нэмэгдэл урамшуулал (хүн/цаг)                              | 6,485            |
| 8  | Гэр бүлийн бус орчинд үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдэд шаардлагатай хоолны зардал                            | 7,464            |
| 9  | Сэтгэл зүйн үйлчилгээ (нэг удаа)  | 30,000           |
| 10 | Хууль зүйн үйлчилгээ (хүн/цаг)  | 8,900            |
| 11 | Эрүүл мэндийн төлбөртэй тусламж үйлчилгээ   | 60,000           |
| 12 | Тусгай хэрэгцээнд тулгуурласан үйлчилгээ (хүн/цаг)  | 8,900            |
| 13 | Хүүхэд хамгааллын үйлчилгээний нэмэлт багц  | 40,000           |
| 14 | Хүүхэд хамгаалал, нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдэд шаардлагатай хүүхэд хөгжлийн хэрэглэгдэхүүн | 50,000           |
| 15 | Хамтарсан багийн гишүүдийн үйл ажиллагааг дэмжих зардал /цайны зардал, сард нэг удаа/                         | 44,000           |
| 16 | Урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлэгч ажилтан, сургагч багшийн цагийн хөлс                                   | 70,000           |
| 17 | Сургалтын хэрэглэгдэхүүн  | 5,000            |
| 18 | Урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжлийн үйлчилгээний зардал                           | 250,000          |
| 19 | Хүүхдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлын зардлын дээд хязгаар /нэг хүүхдэд/                                 | 14,000           |
| 20 | Олон нийтэд чиглэсэн сургалт, нөлөөллийн зардлын дээд хязгаар /нэг хүүхдэд/                                   | 660              |
| 21 | Гэр бүлд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлын зардлын дээд хязгаар /нэг хүнд/                                   | 660              |
| 22 | Боловсон хүчин чадавхжуулах зардлын дээд хязгаар /нэг хүнд/   | 170,000          |
| 23 | Сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд оролцогчдын цайны зардал  | 5,500            |